АЖЛЫН БАЙР (АЛБАН ТУШААЛ)-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

☑ Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн нэр, огноо: "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/49 дүгээр тушаал

Албан тушаалын тодорхойлолтын дугаар: "ИНҮТ" ТӨХКК - 96

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо, дугаар: 2025.03.14 А/124

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК	Нисэх буудлуудын үйлчилгээний газар
Албан тушаалын нэр:	Албан тушаалын ангилал, зэрэглэл:
Аэродром, гэрэл суулт хариуцсан ахлах технологич мэргэжилтэн	
Ажлын цаг:	Ажлын байрны албан ёсны байршил:
Ердийн	ХУД-ийн 21-р хороо, "ИНҮТ" ТӨХХК
Хөдөлмөрийн нөхцөл:	Онцгой нөхцөл:
Хэвийн	

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Нисэх буудлуудын аэродромын хөгжлийн бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийг төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, журмуудтай уялдуулан төлөвлөх, үйл ажиллагааны технологийг сайжруулах, "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн салбар нисэх буудлуудын аэродромын шаардлагатай стандарт, технологи, норм норматив хангуулан, ИНД-үүдийн гэрчилгээжүүлэлтэд хяналт тавьж ажиллах

Албан тушаалын зорилт:

1. Аэродромын холбогдох стандарт, баримт бичгийг төв болон орон нутгийн нисэх буудлуудад технологийн дагуу мөрдүүлж ажиллуулах, мэргэжлийн удирдлагаар хангах;
2. ИНЕГ-аас ИНД-139-ийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор өгсөн зөвлөмж, үл тохирлын нийцлүүдийг нэгтгэж, үйл ажиллагааны төлөвлөгөө болгон боловсруулах ажлыг удирдаж, мэргэжилтнүүдийг удирдлагаар хангах, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
3. Монгол Улсын нисэх буудал, аэродромын ерөнхий төлөвлөлтийг хийхэд мэргэжил арга зүйгээр хангах;
4. Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдах аэродром болон аэродромын байгууламжуудын ажилд инженерийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах;
5. Нисэх буудлын үйл ажиллагаанд оролцдог бусад дүрмийн зохицуулалттай нислэгийн хөдөлгөөний, холбоо навигацийн, нислэгийн мэдээллийн үйлчилгээ хоорондын үйлдвэрлэл технологийн үйл ажиллагааны заавар, журмын хоорондын уялдаа холбооны зохицуулалтыг инженерийн аргаар, төлөвлөлтөөр хийж гүйцэтгэж ажиллах;
6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан

			гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1 "Монгол Улсын аэродромын стандарт"-ыг түүнд нийцэж гаргасан дүрэм, журмыг баримтлан үйлдвэрлэлд нийцүүлэх ажлыг хэрэгжүүлэх; 1.2 Олон улсын иргэний нисэхийн стандарт, зөвлөмжийн хэрэгжилт Монгол Улсын аэродромуудад хэрхэн нийцэж байгаа эсэхэд хяналт тавих, судлах, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах; 1.3 Монгол Улсын аэродромуудын нислэгийн үйл ажиллагаатай холбоотой аливаа стандарт, дүрэм журмын хэрэгжилтэд гарч байгаа үл нийцэл, дутагдалд хяналт тавьж, засаж сайжруулах, хоорондын уялдаа холбоо, үйл ажиллагааны зохицуулалтыг хангах чиглэлээр санал боловсруулах, хэрэгжүүлэх;	Аэродромын холбогдох стандарт, баримт бичгүүд мөрдөгдөж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа тогтмолжсон байна.	Г, Х Г, Х Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	2.1 Олон улсын болон орон нутгийн аэродромуудын үйлчилгээг ИНД-139-д тавигдсан шаардлагад нийцүүлэн хангуулах ажлын төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулж, хяналт тавих; 2.2 Нисэх буудалд нислэг үйлдвэрлэл явагдаж байгаатай холбоотойгоор ИНД-139 дүрмийг хэрэгжүүлэхэд болзошгүй эрсдэлийг тогтоох, бууруулах, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр судалгаа хийж, хяналт тавьж ажиллах; 2.3 ИНЕГ-ын байцаагчаас ирүүлсэн болон бусад хөндлөнгийн хяналтын байгууллагаас ирүүлсэн дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах;	Нисэх буудлуудын үйл ажиллагаа Олон улсын стандарт, шаардлага болон ИНД-ийн шаардлагыг хангасан байна.	Г, Х Г, Х Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	3.1 Олон улсын аэродромын стандартыг үндэсний хэмжээний стандарт болгож нутагшуулах ажлыг биечлэн удирдаж, стандарт болгож боловсруулах ажлын судалгаануудыг хийж боловсруулан танилцуулах; 3.2 Аэродром, нисэх буудлын дизайн төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөг хийх ажлыг мэргэжилтнүүдтэй хамтран хийж, санал боловсруулан нисэх буудлуудын хөгжлийн бодлого, хөтөлбөртэй уялдуулах; 3.3 Нисэх буудал, аэродромын стандартыг дагаж гарсан норм, нормативуудыг шинэчлэн батлуулах ажлыг санаачлан хийх, төсөл хэрэгжүүлэх; 3.4 ИНД-157-н дагуу шинээр аэродром байгуулах, судалгаа шинжилгээний ажилд оролцох, гүйцэтгүүлэх, хяналт тавих; 3.5 Аэродром, нисэх буудлуудын төлөвлөлтийн ажлын хүрээнд иргэний нисэхийн чиглэлээр гадны улс орнуудын туршлагыг судлах; 3.6 Нисэх буудлуудын жил бүрийн аэродромын холбогдох хөрөнгө оруулалт, урсгал зардлын гүйцэтгэл биелэлтийн нэгдсэн судалгааг хийж, төлөвлөлтөд шаардлагатай мэдээлэл, материал боловсруулах төлөвлөгөөг нэгтгэх;	Монгол улсын аэродромууд төлөвлөлтийн нэгдсэн нэг стандарт, норм норматив, барих ажлын нэгж үнэлгээтэй болж төлөвшсөн байна.	Г, Х Г, Х Г, Х Г, Х Г, Х Г, Х

	3.7 Буянт-Ухаа Олон улсын нисэх буудлын аэродромын аюулгүйн бүс, саад, саадын хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах;		Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1 Төв болон орон нутагт аэродром барьж байгуулах ажилд аэродромын инженерүүдийг нэгтгэн удирдаж, инженерийн хяналтыг хийж гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах; 4.2 Хөрөнгө оруулалтаар баригдсан ажлуудыг ашиглалтад хүлээж авах ажилд мэргэжлийн дагуу хяналт тавьж оролцох; 4.3 Аэродром барьж байгуулах, өргөтгөх, шинэчлэх урсгал засвар хийхтэй холбогдсон инженерийн тоо хэмжээг гаргах ажлыг хариуцан зохион байгуулах;	Аэродром болон аэродромын байгууламжуудын ажил нэгдсэн зохион байгууллалттай зөв төлөвлөгдсөн байна.	Г, Х Г, Х Г, Х
5 дугаар зорилтын хүрээнд	5.1 Нисэх буудлын үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай үйл ажиллагааны заавар, хамтын ажиллагааны журам, зааврыг боловсруулалтад хяналт зохицуулалт хийж гүйцэтгэх; 5.2 Нисэх буудлууд болон үйлдвэрлэлийн нэгж хоорондын уялдаа холбоог хангаж ажиллах; 5.3 Аэродромын үйл ажиллагааны баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах, саналыг тусгах;	Аэродромын холбогдох баримт бичиг боловсронгуй болсон байна.	Г, Х Г, Х Г, Х
6 дугаар зорилтын хүрээнд	6.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, өөрийн харьяалах ажлын байр болон үйлдвэрлэлийн орчинд тохирсон дүрэм, журмыг боловсруулахад оролцох; 6.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тооцох, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхэд ажилтнаа манлайлан ажиллах; 6.3 Осолд дөхсөн тохиолдлыг бүртгэх болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн орчинд учирч болох аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах талаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтанд мэдээлэх, хамтран ажиллах; 6.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.3,28 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд ажил олгогч болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтантай хамтран ажиллах;	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна.	Г, Т Г, Х, Т Г, Т Г, Т
Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа	• Удирдлагын өгсөн чиглэлээр санал боловсруулах, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, ажлын явцыг удирдлагад танилцуулах; • Үйл ажиллагаатай холбогдол бүхий санал, зөрчлийн мэдээллийг удирдлагад мэдэгдэх, зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах; • Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, төрийн захиргааны төв байгууллагын болон компанийн гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэр, цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;	Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар, ажлын байрны хүрээнд явагдсан бусад үйл ажиллагаа бүрэн хангагдсан байна.	Г Г Г

	• Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, гүйцэтгэлийн тайланг гаргаж, тогтоосон хугацаанд үнэлүүлэх; • Хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан байгууллагын соёл, эрхэмлэх үнэт зүйлс, ажилтны манлайлал, ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгон ажиллах; • Мэдлэг ур чадвараа дээшлүүлэх талаар идэвх чармайлт, санал, санаачилга гарган ажиллах; • Компанийн "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ын дагуу баримт, материалыг архивын нэгж бүрдүүлэн бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөх; • Аэродромын үйл ажиллагаа хариуцсан менежерийг ээлжийн амралттай, захиргааны чөлөөтэй болон өвчтэй байх үед орлон ажиллах;		Г Г Г Г Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй	
Мэргэжил	Аэродромын инженер Авто замын инженерчлэл (073210) Барилгын инженерчлэл (073204)	
Мэргэшил	Аэродром, иргэний нисэхийн болон нисэх буудлын менежментийн чиглэлээр сургалтад хамрагдсан байх.	
Туршлага	Иргэний нисэхийн салбарт 5-аас доошгүй жил ажилласан, үүнээс аэродромын чиглэлээр 3-оос доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	• Мэдээллийн дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; • Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; • Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх. • Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх. • Дүн шинжилгээ хийх
	Асуудал шийдвэрлэх	• Хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; • Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; • Албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйг сахиж, ашиг сонирхлоос аливаа зөрчлөөс сэргийлж, авлига, хүнд суртлаас ангид ажиллах; • Асуудлыг цогцоор нь шийдвэрлэх чадвар; • Төлөвлөлт болон зохион байгуулах чадвар;
	Багаар ажиллах чадвар	• Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; • Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; • Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; • Өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх; • Зааварлан удирдах чадвартай байх;
	Бусад	• Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; • Монгол хэл, бичгийн дүрмийн дагуу үг үсгийн болон утга найруулгын алдаагүй бичих; • Монгол бичгийн анхан шатны мэдлэгтэй байх; • Компьютерын өргөн хэрэглээний программуудыг ашиглаж чаддаг байх; • Албан тушаалын чиг үүрэгт хамаарах асуудлаар англи хэл, бусад гадаад хэлээр мэдээллийн эх сурвалж ашиглах; • Ачаалал даах чадвартай байх; • Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын менежмент сайтай байх;

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Нисэх буудлуудын үйлчилгээний газрын дарга, нисэх буудлын үйл ажиллагаа харуцсан менежер	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: - Аэродромын үйл ажиллагаа хариуцсан технологч мэргэжилтэн -2 - Орон нутгийн нисэх буудлууд - Газрын харьяа салбар, нэгжүүд	Бусад харилцах субъект: - ИНЕГ, Компанийн харьяа салбар, нэгжүүд - Иргэний нисэхийн салбарын бусад байгууллагууд - Агаарын тээвэрлэгч байгуулагууд - Орон нутгийн нисэх буудлууд - Ажил хэргийн хүрээнд харилцах бусад байгууллага, иргэд

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: ЗАХИРГАА, САНХҮҮ ХАРИУЦСАН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР ..... Н.ЗОЛЖАРГАЛ 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдөр	Байгууллагын нэр: “ИНҮТ” ТӨХХК Шийдвэрийн огноо: 2025.02.18 Дугаар: А/49

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: “ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК

Шийдвэрийн огноо: 2025 оны 03 дугаар сарын 14 өдөр

Дугаар: А/124

(тамга/тэмдэг)

“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ОТГОНСҮХ

2025 оны 03 дугаар сарын 14-ны өдөр